



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 17 өдөр

Дугаар А/503

Булган сум

Карьер ашиглах түр зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2014 оны 222 дугаар тогтоолоор батлагдсан “Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай журам”-ын 5.3, 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Орхон сумын төвийн хатуу хучилттай авто зам барих ажлын үргэлжлэл”-д шаардагдах шороон орд, чулууны карьерын байршлын координатыг хавсралтаар баталсугай.

2.Дээрх ажилд карьер ашиглах түр зөвшөөрлийг 2024 оны 08 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд зураг, төсвийн дагуу гүйцэтгэж, ашиглалтад хүлээлгэн өгөхийг “Энх-Алтаргана” ХХК (А.Энхжаргал)-д олгосугай.

3.Чулуун карьер түр ашиглуулах гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг хангаж, нөхөн сэргээлтийн ажлыг чанарын өндөр түвшинд хийлгэж, хүлээн авч ажиллахыг Орхон сумын Засаг дарга (Н.Амартүвшин)-д үүрэг болгосугай.

4.Тус компанийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Г.Давааням), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Ү.Бямбасүрэн), Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (А.Гантөмөр), Татварын газрын дарга (Д.Лхагвасүрэн) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ



632401079

Аймгийн Засаг даргын 2024 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн 1/52 дугаар захирамжийн хавсралт

Шороон орд, чулуун карьерын байршил

№	Нэр	Ажлын зургийн байршил	Координат		
			№	Уртраг	Өргөрөг
1	Карьер 1	Орхон сум 4-р баг, Мааньт	1	103° 54' 13.8"	48° 55' 16.3"
			2	103° 54' 24.1"	48° 55' 15.4"
			3	103° 54' 19.0"	48° 55' 09.2"
			4	103° 54' 11.0"	48° 55' 10.6"
2	Карьер 2	Орхон сум 5-р баг, Мандал	1	103° 31' 17.5'	48° 37' 15.0"
			2	103° 31' 17.5"	48° 37' 14.2"
			3	103° 31' 16.4"	48° 37' 14.4"
			4	103° 31' 16.4"	48° 37' 14.9"